



ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД,
УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

2017 оны 10 дугаар
сарын 18-ны өдөр

Дугаар А-260/А/112

Улаанбаатар
хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 290.3 дахь хэсэгт заасныг үндэслэн
ТУШААХ НЬ:

1. “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэ журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар /бригадын генерал Ц.Амгаланбаяр/, тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Г.Баясгалан/, Улсын ерөнхий прокурорын газрын Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтэс /Э.Амарбат/ нарт тус тус даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Хууль зүйн, дотоод хэргийн сайдын 2002 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 275 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР,
ТӨРИЙН ХУУЛЬ ЦААЗЫН ТЭРГҮҮН
ЗӨВЛӨХ

С.БЯМБАЦОГТ

М.ЭНХ-АМГАЛАН

Хууль зүй, дотоод хэргийн сайд,
Улсын Ерөнхий прокурорын
хамтарсан 2017 оны 10 дугаар
сарын 18-ны өдрийн А-260/А/112
дугаар тушаалын хавсралт

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧ БИЕИЙН ХҮЧ,
ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ, ГАЛТ ЗЭВСЭГ ХЭРЭГЛЭХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч /цаашид “алба хаагч” гэх/ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 290-298 дугаар зүйлд заасан үндэслэл, журмын дагуу биеийн хүч, нэг бүрийн болон олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэхтэй холбоотой харилцааг зохицуулна.

1.2.Алба хаагч биеийн хүч, нэг бүрийн болон олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэхдээ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, түүнд нийцүүлэн баталсан эрх зүйн баримт бичиг, энэхүү журмыг баримтална.

1.3.Алба хаагч нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын албан хэрэгцээнд хүлээн авч, бүртгэж, олгосон тусгай хэрэгсэл, галт зэвсгийг хэрэглэнэ.

1.4.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 298.1-д заасны дагуу галт зэвсэг хэрэглэх эрх олгох сургалт, дадлагыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага зохион байгуулна.

1.5.Цэргийн мэргэжлийн болон хууль сахиулах чиглэлээр боловсрол олгох их, дээд сургуульд галын бэлтгэлийн хичээл, сургалтад хамрагдсан дээд боловсролын гэрчилгээ, мэргэжлийн үнэмлэх бүхий алба хаагчийг галт зэвсэг хэрэглэх эрх олгох сургалт, дадлагад хамрагдаж, эрх олгогдсон гэж үзнэ.

1.6.Алба хаагч нь үүссэн нөхцөл байдлыг үнэлж дүгнэн, өөрийн дотоод итгэл үнэмшлээр, тухайн нөхцөл байдалд тохируулан биеийн хүч, нэг бүрийн тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх шийдвэрийг бие даан гаргана.

Хоёр. Биеийн хүч хэрэглэх

2.1.Алба хаагч нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 291 дүгээр зүйлд заасан нөхцөл байдал бий болсон үед биеийн хүч хэрэглэнэ.

2.2. Үүссэн нөхцөл байдалд тохируулан бие хамгаалах, үйлдлийг таслан зогсоох, хяналтад авах зорилгоор хориглоогүй бүх төрлийн барилдаан, тулааны мэх хэрэглэж болно.

2.3. Эхний мэх хийсний дараа хор аюул арилаагүй нөхцөлд давтан болон өөр мэхийг сонгож, үргэлжлүүлэн уг хор аюулыг таслан зогсоох арга хэмжээг бүрэн авна.

Гурав. Нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх

3.1. Алба хаагч нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 294 дүгээр зүйлд заасан тохиолдолд нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэнэ.

3.2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь алба хаагчийг албан үүргээ гүйцэтгэх үед нь нэг бүрийн тусгай хэрэгслийг олгоно.

3.3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 294 дүгээр зүйлд заасан нөхцөл байдалд тохируулан нэг бүрийн тусгай хэрэгслийг давхардуулан хэрэглэж болно.

3.4. Нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэхдээ бололцоотой бүх тохиолдолд тусгай хэрэгсэл хэрэглэх тухайгаа урьдчилан сануулна.

3.5. Алба хаагч нь гавыг баривчлагдсан этгээд, цагдан хоригдсон яллагдагч, хоригдол өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх, хуяглан хүргэх ажиллагааны явцад аюулгүй байдлыг хангах зорилгоор хэрэглэнэ.

3.6. Гавыг дараахь байдлаар хэрэглэнэ:

3.6.1. хоёр гарыг биеийн урд болон ард бугуйгаар нь холбож гавлах;

3.6.2. хоёр гарын эрхий хурууны нэгдүгээр үеийн хойгуур нь холбож гавлах;

3.6.3. хоёр ба түүнээс дээш хүний гар болон хөлийг хооронд нь холбож гавлах;

3.6.4. бүсэлхийд зүүсэн бүстэй холбож 2 гарыг гавлах;

3.6.5. хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулахгүй зүйлтэй түр хугацаагаар холбож гавлах.

3.7. Гав хэрэглэхдээ дор дурдсаныг анхаарч, аюулгүй байдлыг хангана:

3.7.1. түлхүүрээр түгжиж, боолтоор чангалахдаа цусны эргэлт зогсоход хүргэх, арьсанд гүн шигдэхгүй байхад анхаарах;

3.7.2.цаг тутамд чангарсан эсэхийг шалгаж үзэх ба шаардлага гарсан үед тухай бүр шалгах;

3.7.4.хуяглан хүргэх явцад тээврийн хэрэгслийн донсолгоонд татагдаж гэмтэхээс сэргийлэх.

3.8.Хүлэгийг өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх зорилгоор гав байхгүй тохиолдолд хүний гар, биед шигдэхээргүй, сунадаггүй, үрж гэмтэл учруулахгүй материалыг сонгож хоёр гарыг урд нь эсхүл ард нь хэрэглэнэ.

3.9.Хүлэг хэрэглэсэн тохиолдолд байнгын хяналтад байлгана.

3.10.Тусгай хэрэгслийн бусад төрлийг хэрэглэсэн боловч үйлдэл нь таслан зогсоогдохгүй бол хорих ангийн ерөнхий жижүүр, ээлжийн даргын шийдвэрээр ороох цамцыг хэрэглэнэ.

3.11.Ороох цамцыг хэрэглэхдээ урд талаас нь хоёр ханцуйг өмсгөж, биеийн урд талд хоёр гар, ханцуйг цээжийг тэврүүлэх байдлаар зөрүүлж ороон, арын бүчүүдийг хөвөрхий уях ба хормойн уяагаар хоёр хөлийн шилбээр ороож уяна.

3.12.Ороох цамцыг нэг цагаас илүү хугацаагаар хэрэглэхгүй ба энэ хугацаанд эмчийн байнгын хяналтад байлгана.

3.13.Ороох цамцыг 60-аас дээш насны эрэгтэй, 55-аас дээш насны эмэгтэй, насанд хүрээгүй, жирэмсэн, хөдөлмөрийн чадвар алдалтын 1, 2-р зэрэгтэй болон эмчийн хяналтад байгаа хүнд хэрэглэхгүй.

3.14.Бороохойг дараахь байдлаар хэрэглэнэ:

3.14.1.хүний биеийн яс, булчин дагуу ороолгох, цохих, хатгах байдлаар үйлдлийг таслан зогсоох;

3.14.2.бамбай бусад зүйлийг цохиж дуу чимээ гаргах байдлаар сэтгэл зүйд нөлөөлөн хяналтад авах;

3.14.3.зэвсгийн чанартай эд зүйл ашиглан довтолсон тохиолдолд түүнээс хамгаалах;

3.15.Бороохойг хэрэглэхдээ дор дурдсаныг анхаарч, аюулгүй байдлыг хангана.

3.15.1.алба хаагчийн амь нас, эрүүл мэндэд хохирол учруулахаар довтолсноос бусад тохиолдолд хүний толгой, хэвлий, бөөр, давсганд цохихгүй байхыг эрмэлзэх;

3.15.2.нэг газарт олон цохихгүй байх, аль болох гэмтэл учруулахгүй байхыг эрмэлзэх;

3.16.Цахилгаан гүйдлээр цохигчийг дараахь байдлаар хэрэглэнэ.

3.16.1.хувцасны гадна талаас цахилгаан хүчдэлийг нэг байрлалд 10 секундээс илүүгүй хугацаагаар үйлчлэхээр хүргэж үйлдлийг таслан зогоож;

3.16.2.дуу чимээ гаргах байдлаар сэтгэл зүйд нөлөөлж хяналтад авах;

3.17.Цахилгаан гүйдлээр цохигчийг хэрэглэхдээ дор дурдсаныг анхаарч, аюулгүй байдлыг хангана:

3.17.1.аль болох хүний нүүр болон биеийн ил хэсэгт хэрэглэхгүй байхыг эрмэлзэх;

3.17.2.ус, чийгтэй орчинд хэрэглэхээс зайлсхийх.

3.18.Нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчийг салхины чиглэл дагуу 1-1.5 метрээс дээш зайд цацах, шүрших, буудах байдлаар хэрэглэнэ.

3.19.Нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчийг хэрэглэхдээ дор дурдсаныг анхаарч, аюулгүй байдлыг хангана.

3.19.1.барилга, байгууламж дотор тухайн бодисын үйлчлэлд өөрөө өртөхгүй байрлалыг сонгох;

3.19.2.нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчийн үйлчлэлд өртсөн хүний эсэргүүцэл, довтолгоо зогссон тохиолдолд түүнд тусгай хэрэгслийн үйлчлэлийг саармагжуулах боломж олгох;

3.19.3.нулимс асгаруулах, амьсгал боогдуулагч хэрэглэсний дараа биеийн байдал муудсан хүнд эмнэлгийн тусламж үзүүлэх;

3.20.Резин болон хуванцар сумтай бууг хэрэглэхдээ үйлдвэрлэгчийн зааврыг баримтлах ба дор дурдсаныг анхаарч, аюулгүй байдлыг хангана:

3.20.1.бууг гал хамгаалагчийг түгжиж биедээ авч явах;

3.20.2.бууны хэвийн ажиллагаа, аюулгүй байдал, зориулалтын сумаар цэнэглэгдсэн эсэхийг шалгах.

Дөрөв.Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх

4.1.Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг хэрэглэхдээ дараахь арга хэмжээг авна.

4.1.1.тусгай хэрэгслийн төрөл, хэмжээ, хэрэглэх хүрээ, дэс дараалал, арга хэлбэрийг тодорхойлох;

4.1.2.олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэсний дараа гэмтсэн, шархадсан хүмүүс байгаа эсэхийг нягтлан, байгаа бол эмнэлгийн тусламж үзүүлэх;

4.1.3.олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийн үйлчлэх хугацаа дуусах хүртэл тухайн орчинд хамгаалалт зохион байгуулж, бусдыг хордохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.

Тав.Бусад тусгай хэрэгсэл

5.1.Хорих байгууллагын алба хаагч нь галт зэвсэг хэрэглэл, гэрэл, дууны нөлөөллийн хэрэгсэл, тусгай будагч болон будган болон будган сумаар бууддаг буу, хөдөлгөөн саатуулах тор, тор шидэгч, орц, гарц гаргах зориулалтын тэсэлгээний хэрэгсэл, хаалга, цонх эвдэгч зориулалтын багаж, согтууруулах болон мансууруулах бодис хэрэглэсэн эсэхийг шалгагч багаж, тээврийн хэрэгслийг албадан зогсоогч зэрэг бусад тусгай хэрэгслийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 292,297 дугаар зүйлд заасан үндэслэл, журмын дагуу, үйлдвэрлэгчийн ашиглах зааврын дагуу хэрэглэнэ.

5.2.Тээврийн хэрэгслийг албадан зогсоох тусгай хэрэгслийг оргон зайлсан яллагдагч, ялтныг баривчлах үед зам, газарт дэлгэн тавьж хэрэглэнэ.

5.3.Тээврийн хэрэгслийг албадан зогсоох тусгай хэрэгслийг хэрэглэхдээ цагдаагийн байгууллагын туслалцааг авна.

5.4.Галт хэрэглэл, орц, гарц гаргах зориулалтын тэсэлгээний хэрэгсэл, гэрэл, дууны нөлөөллийн хэрэгслийг хэрэглэхдээ дараах зүйлийг анхаарч, аюулгүй байдлыг хангана.

5.4.1.Галт хэрэглэл, орц, гарц гаргах зориулалтын тэсэлгээний хэрэгслийг ашиглахдаа барилга, байгууламжийн бүтэц, хийцэд нөлөөлж нуранги үүсэх, хүн дарагдаж гэмтэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах;

5.4.2.гэрэл, дууны нөлөөллийн хэрэгслийг 2 метрээс дотогш зайд шидэхгүй байх.

Зургаа.Галт зэвсэг хэрэглэх

6.1.Хорих ангийн алба хаагч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай 297 дугаар зүйлд заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд галт зэвсэг хэрэглэнэ.

6.2.Галт зэвсэг хэрэглэхийн өмнө сануулахдаа гадна орчинд дээш 1 удаа хий буудах ба барилга, байгууламж зэрэг орчинд галт зэвсэг хэрэглэх бол энэ тухай анхааруулна.

6.3.Алба хаагч нь галт зэвсэг хэрэглэсэн тохиолдолд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 298.6-д заасан журмыг баримталж ажиллана.

Долоо.Бусад зүйл

7.1.Алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэсэн тохиолдолд бүрт тэмдэглэлийг 2 хувь хөтлөн, 1 хувийг шууд захирах даргад, 1 хувийг өөртөө хадгална.

7.2.Яллагдагч, хоригдлыг хуяглан хүргэх ажиллагаанд гав хэрэглэсэн тохиолдолд энэ журмын 7.1-д заасан тэмдэглэл үйлдэхгүй.

7.3.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч нь тусгай хэрэгсэл, галт зэвсгийг албан үүрэг гүйцэтгэх үедээ биедээ авч явах эрхтэй бөгөөд бусдад дамжуулах, шилжүүлэхийг хориглоно.

7.4.Тусгай хэрэгсэл, галт зэвсгийг гээгдүүлсэн, үрэгдүүлсэн, бусдад шилжүүлсэн алба хаагчид хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

---oo0oo---